БАТЛАВ.
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙНДАРГА, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ОРОН ТООНЫ БУС ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ОРОН ТООНЫ БУС ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Үйл ажиллагаа | Хүрэх түвшин | Шалгуур үзүүлэлт/тоо хэмжээ | Хэрэгжих хугацаа | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|
| **Зорилго** | Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах, орон сууц, олон нийтийн барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, салбарт тэдний оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд холбогдох арга хэмжээг авах. /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9, 17 дугаар зүйл/ | | | |
| **Зорилт** | 1. Дэд зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн, хүртээмжтэй явуулж дараах гол зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлд ажиллах;<br>2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцлийг сайжруулах;<br>3. Срон сууц, олон нийтийн барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх;<br>4. ХБИ-ийн оролцоог салбарын үйл ажиллагаанд болон тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх;<br>5. ХБИ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, худалдан авалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | | | |
| **Зорилт 1. Дэд зөвлөлийн үйл ажиллагааг хүртээмжтэй явуулах, хөгжлийн бэрхшээл, нийтийн хүртээмжийн талаар мэдлэг ойлголт түгээх:** | | | | |
| 1.1. Дэд зөвлөлийн ээлжит хуралдааныг зохион байгуулах, үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, мэдээлж ажиллах. | Хуралдааныг зохион байгуулж, тайлан, төлөвлөгөөний төслийг танилцуулж, гишүүдээс санал авч тусгасан байна. Тайлан, төлөвлөгөөг холбогдох байгууллагуудад хугацаанд хүргүүлсэн байна. | 1.Хуралдааны тоо;<br>2.Төлөвлөгөөний төсөл хэрэгжихүйц байх, хэрэгжилтийн хувь | I-IV улиралд | ХНХЯ, ГЗБГЗЗГ, БХТ, ТББ-ууд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Холбогдох байгууллагуудтай хамтран төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна. | | | |
| 1.2. Салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, аюулгүй байдал, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлд сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах. | Дараах сургалтуудыг зохион байгуулсан байна.<br>1. Хөгжлийн бэрхшээл, нийтийн хүртээмж, нийгмийн хандлага, харилцаа, хөгжлийн талаарх сургалт;<br>2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, ажил олгогч нар ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдалд нийцүүлэх сургалт;<br>3. Холбогдох норм ба дүрмийг сурталчлах, зураг төсөлд тусган хэрэгжүүлэх, Хөдөлмөрийн тухай хуль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль зэрэг холбогдох бодлого, эрх зүйн орчны талаар.<br>Салбарын инженер техникийн ажилтнуудад мэргэшлийн зэрэг олгох болон бусад богино хугацааны сургалтын хөтөлбөрт дээрх чиглэлийн сургалтуудыг тусгасан байна.<br>Сургалтад яам, харьяа байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийг хамруулсан байна. | 1.Сургалт, нөлөөллийн ажлын тоо;<br>2.Сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо. | I-IV улиралд | БХБЯ, ХНХЯ, ГЗБГЗЗГ, БХТ, ТББ-ууд, ААН-үүд |
| **Зорилт 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах:** | | | | |
| 2.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд саадгүй оролцох, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.<br>(ЗГҮАХХАХТ-2.5.8) | ХБИ-ийн эрх ашигт нийцсэн, тэдний дэд бүтцийн хүртээмжтэй холбоотой норм, стандартад санал өгч, батлуулах чиглэлээр ажилласан байна.<br>Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөлд санал өгсөн байна.<br>Барилга, хот байгуулалтын салбарт | 1.Хуулийн төсөл, норм ба дүрэм, стандартын санал;<br>2.ХБИ-нд хүртээмжтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийн | I-IV улиралд | БХБЯ-ны БТГ, БХТ, ТББ-ууд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хамаарах хүртээмжтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалтыг гарган дүгнэлт хийж, холбогдох арга хэмжээг авна. | жагсаалт-1. | | |
| 2.2.Түрээсийн орон сууцны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх. | - ХБИ-ээс түрээсийн орон сууцанд хамрагдах тоо нэмэгдэнэ.<br>- "Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам" болон бусад актуудад өөрчлөлт оруулж боловсруулж, батлуулна. | Журамд тусгагдсан байх. | II-IV улиралд | БХБЯ-ны ОССХ ХНХЯ, Сангийн яам, ТББ-ууд |
| 2.3. Ипотекийн шаардлагыг хангасан ХБИ-ийг уг зээлд хамруулах, дарааллыг урагшлуулах зэрэг чиглэлд дэмжлэг үзүүлэх. | - Хүсэлт гаргасан ХБИ-ийг ипотекийн зээлд хамруулах чиглэлд дэмжлэг үзүүлнэ. | Зээл хамрагдсан иргэдийн тоо | II-IV улиралд | БХБЯ-ны ОССХ ТББ-ууд |
| 2.4. Халамжийн орон сууцны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, холбогдох талуудаар хэлэлцүүлж, батлуулж, хэрэгжилтийг эхлүүлэх чиглэлээр ажиллана. | - Холбогдох эрх зүйн болон бусад судалгааны ажлуудыг хийнэ.<br>- Хэлэлцүүлэг зохион байгуулна.<br>- Хөтөлбөр, төлөвлөгөө тус бүр 1 баримт бичиг боловсруулж, батлуулна. | 1.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулсан байна.<br>2.Хөтөлбөр, төлөвлөгөө тус бүр 1 баримт бичиг.<br>3.Хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйс, байгууллагаар. | I-IV улиралд | БХБЯ-ны ОССХ ХНХЯ, Сангийн яам, ТББ-ууд |
| **Зорилт 3.** **Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх:** | | | | |
| 3.1.Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын даалгаварт ХБИ-д зориулсан тусгай шаардлага, холбогдох норм ба дүрэм, стандартуудыг тусгаж, хэрэгжүүлэх, хяналт тавин шаардлага хангасан барилга байгууламжийг ашиглалт авах ажлыг зохион байгуулах.<br>*(Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дэх заалт, 15 дугаар заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний* | 1. "Бүх хүн түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж барилга байгууламжийн орон зай, орчны хүртээмжийг дээшлүүлэх (хангах) төлөвлөлт" Барилгын норм ба дүрэм БНбД 31-...-21 -ийг батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.<br>2. Барилгын тухай хууль болон норм дүрэм, технологийн шаардлага | 1. Зураг төсөл, ажлын даалгаварын тоо;<br>2. Норм ба дүрэм, стандарт, хүртээмжтэй байх шаардлага хангасан барилга байгууламжийн тоо. | I-IV улиралд | ГЗБГЗЗГ, БХТ, Монголын зураг төсөл зохиогчдын холбоо, ТББ-ууд, ААН-үүд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| *эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл)* | хангасан зураг төслийг магадлан баталгаажуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.<br>**3.** БХТ-ийн Магадлалын хэлтэс тайлангаа БХБЯ-ны удирдлагын зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн хуралдаанд хагас жил тутамд тавьж, хэлэлцүүлнэ. | 3. Тайлангийн хэрэгжилтийн хувь. | | |
| 3.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд барилга байгууламж, дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах ажлыг нийслэл, орон нутагт үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.<br>*(Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 дэх заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл)* | - Барилга байгууламжуудад үзлэг хийж, шаардлага хангахгүй барилга байгууламжийг ХБИ-д хүртээмжтэй болгон шинэчлэх асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлсэн байна.<br>- Холбогдох норм ба дүрэм, стандартуудыг барилга байгууламжийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн байна.<br>- Харьяа 2-оос доошгүй байгууллагын хүртээмжтэй байдлыг сайжруулсан байна.<br>- Яам, харьяа байгууллагуудын вэбсайтуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох чиглэлд ажиллана. | 1.Үзлэгт хамруулсан барилгын тоо;<br><br>2.ХБИ-ийн хэрэгцээнд нийцүүлэн засварласан барилгын тоо. | I-IV улиралд | БХБЯ-ны ББМҮБХЗГ, ГЗБГЗЗГ, БХТ, ААН, ТББ-ууд |
| 3.3. "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ болон харьяа байгууллагуудын "Нэг цэгийн үйлчилгээ"-нд ХБХ-нд дараалал харгалзахгүй үйлчлэх арга хэмжээг хэвшүүлэх. | - Үйлчилгээний хүртээмжийг сайжруулах тэмдэг, шошгийг ашигласан байна.<br>- Нийтэд зарласан байна. | Үйлчилгээг хүртээмжтэй болгосон цэгүүдийн тоо. | I-IV улиралд | БХБЯ-ны ББМҮБХЗГ, ГЗБГЗЗГ, БХТ, Аймаг, Нийслэлийн ГХБХБГ, ААН, ТББ-ууд |
| **Зорилт 4. Салбарын болон нийгмийн үйл ажиллагаанд ХБИ-ийн оролцоо ба тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд** | | | | |
| 4.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах, ажлын байраар хангах чиглэлд холбогдох арга | - ХБИ сургалтад хамрагдаж, ажлын байраар хангагдсан байна.<br>- Салбарын төрийн, төрийн бус, хувийн | 1.Сургалтын болон ажил эрхлэгч иргэдийг тоо. | II-IV улиралд | БХБЯ-ны ТЗУГ, СМТХ, ХНХЯ, ГЗБГЗЗГ, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| хэмжээг авах ба хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хамруулах. *(Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2)* | хэвшлийн байгууллагуудад ажиллаж буй ХБИ-ийн тоо нэмэгдсэн байна. | | | БХТ |
| 4.2.Барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжийн зураг төсөл боловсруулах, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах комисст ХБИ-ийн төлөөллийг оролцуулж байх. *(Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл)* | - ХБИ-ийн ТББ-ын болон бусад иргэнийг барилга байгууламжийн үйл ажиллагаанд оролцуулсан байна. | Комисст ажилласан болон үйл ажиллагаанд оролцсон иргэдийн тоо | II-IV улиралд | БХБЯ-ны ТЗУГ, ББМҮБХЗГ, ГЗБГЗЗГ, БХТ, ТББ-ууд |
| 4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт сурч боловсроход шаардлагатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. *(Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 15 дугаар зүйлийн 15.1.2)* | - Аймаг, Нийслэлийн тусгай хэрэгцээтэй сургуулийн сурагчдийн хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр дэмжлэг үзүүлсэн байна. | Дэмжлэг үзүүлсэн ажил, тоног төхөөрөмжийн тоо. | II-IV улиралд | БХБЯ-ны ТЗУГ, ГЗБГЗЗГ, БХТ, ТББ-ууд |
| **Зорилт 5: ХБИ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, худалдан авалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.** | | | | |
| 5.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтад дэмжлэг үзүүлэх. | - Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг ашиглах зорилтот худалдан авалтад дэмжлэг үзүүлнэ. | Бүтээгдэхүүний сурталчилгаа, худалдан авалтын тоо. | II-IV улиралд | БХБЯ-ны ТЗУГ, ГЗБГЗЗГ, БХТ, ТББ-ууд |
| 5.2. "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалтын төрөлд оны шилдэг"-ийг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж, холбогдох байгууллагад хүргүүлэх. *("Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдгийг шалгаруулах журам"-ын 2.1.7)* | - Салбарын бүтээн байгуулалтуудаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй шилдгийг шалгаруулж, ХНХЯ-нд хүргүүлсэн байна. | 1 доошгүй байгууллага/ААН | IV улиралд | БХБЯ, ХНХЯ, БХТ |
| Нийт 5 зорилт, 14 арга хэмжээ төлөвлөв. | | | | |

----------***----------